



ЁС СУРТАХУУНЫ ДҮРЭМ БА МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ

УДИРТГАЛ

CFA Институтын Ёс суртахууны дүрэм ба Мэргэжлийн үйл ажиллагааны стандарт нь CFA Институтын үнэ цэнийн үндэс суурь нь бөгөөд нийгмийн сайн сайхны төлөө ёс суртахуун, боловсрол, мэргэжлийн ур чадварын хамгийн өндөр стандартыг дэмжих замаар дэлхийн хөрөнгө оруулалтын мэргэжлийн салбарыг манлайлах эрхэм зорилгоо хэрэгжүүлэхэд маш чухал юм. Санхүүгийн зах зээл болон хөрөнгө оруулалтын мэргэжлийн салбарт итгэх олон нийтийн итгэлийг хамгаалахад амин чухал зүйл бол ёс суртахууны өндөр стандарт юм. Анх 1960-аад онд зохиогдсоноосоо хойш Ёс суртахууны дүрэм ба Мэргэжлийн үйл ажиллагааны стандарт нь CFA Институтын гишүүдийн шударга байдлыг дэмжиж ирсэнээс гадна албан тушаал, соёл болон тухайн орон нутгийн хууль, дүрэм журмын ялгааг үл харгалзан дэлхийн хөрөнгө оруулалтын салбарын мэргэжилтнүүдийн ёс суртахууны хэм хэмжүүрийн загвар болж ирлээ. CFA Институтын бүх гишүүд (the Chartered Financial Analyst® [CFA®] Цол эзэмшигчдийг оруулан) болон CFA Цол горилогчид нь Ёс суртахууны дүрэм ба Мэргэжлийн үйл ажиллагааны стандартыг дагаж мөрдөх үүрэгтэй ба өөрийн ажил олгогчдоо энэхүү үүргийнхээ талаар мэдээлэх нь зохистой. Зөрчил гаргасан тохиолдолд CFA Институтын зүгээс сахилга батын шийтгэл оноож болно. Гишүүний эрхийг цуцлах, CFA Цол горилогчийн бүртгэлийг хүчингүй болгох болон CFA Цолыг ашиглах эрхийг цуцлах зэрэг сахилгын шийтгэлийг авч болно.

ЁС СУРТАХУУНЫ ДҮРЭМ

CFA Институтын гишүүд (CFA Charterholder гишүүдийг оруулан) болон CFA Цол горилогчид ("Гишүүд болон Цол горилогчид") нь дараах ёс суртахууны зарчмуудыг мөрдөх ёстой:

- Олон нийт, харилцагчид, ирээдүйн боломжит харилцагчид, ажил олгогчид, ажилчид, хөрөнгө оруулалтын мэргэжлийн салбарт хамт ажиллагсад болон дэлхийн хөрөнгийн зах зээлийн бусад бүх оролцогчидтой харилцахдаа шударга, мэргэжлийн ур чадвартай, хичээнгүй, хүндэтгэлтэй бөгөөд ёс суртахуунтай байх.
- Хөрөнгө оруулалтын мэргэжлийн салбарын шударга байдал болон харилцагчидын ашиг сонирхлыг өөрийн хувийн ашиг сонирхлоос өмнө тавих.
- Хөрөнгө оруулалтын судалгаа хийх, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулах үйл ажиллагааг явуулах болон бусад мэргэжлийн үйл ажиллагаанд оролцоходоо зохих түвшиний анхаарал хандуулж, хараат бус байдлаар мэргэжлийн дүгнэлт гаргаж байх.
- Салбарын болон өөрсдийн нэр хүндэд сайнаар нөлөөлөх хэмжээнд мэргэжлийн бөгөөд ёс суртахуунтайгаар биеэ авч явах, тус салбарт ажиллаж буй бусад мэргэжилтнүүдийг мөн тийм байхыг дэмжих.
- Нийгмийн сайн сайхны төлөө дэлхийн хөрөнгийн зах зээлийн хөгжил болон шударга байдлыг дэмжих.
- Мэргэжлийн ур чадвараа хадгалж, дээшлүүж байх, хөрөнгө оруулалтын мэргэжлийн салбарт ажиллаж буй бусад мэргэжилтнүүдийн ур чадварыг хадгалах, дээшлүүлэхэд хүчин чармайлт гаргах.

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАНДАРТ

I. МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАР

- A. Хуулийн мэдлэг.** Гишүүд болон Цол горилогчид нь тэдний мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулдаг засгийн газар, зохицуулагч байгууллага, зөвшөөрөл олгогч байгууллага болон мэргэжлийн холбооны зүгээс баталсан бүх хууль, дүрэм, журмууд (CFA Институтын Ёс суртахууны дүрэм, Мэргэжлийн үйл ажиллагааны стандартыг оруулан)-ыг ойлгож, мөн дагаж мөрдөж байх ёстой. Эдгээр хууль, дүрэм, журмуудын хооронд зөрчил үүссэн тохиолдолд Гишүүд болон Цол горилогчид нь аль илүү хатуу чанга хууль, дүрэм, журмыг нь дагаж мөрдөх ёстой. Гишүүд болон Цол горилогчид нь эдгээр хууль, дүрэм, журмуудыг мэдсээр байж зөрчих, зөрчихөд нь бусдад туслах ёсгүй бөгөөд ийм зөрчилөөс өөрийгөө тусгаарлах ёстой.
- B. Хараат бус байдал ба үнэн зөв дүгнэлт гаргах чадвар.** Гишүүд болон Цол горилогчид нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа хараат бус, үнэн зөв дүгнэлтэд хүрэх болон тус хараат бус байдлаа хадгалахын тулд зохих түвшиний анхаарал хандуулж, шийдвэр гаргадаг байх ёстой. Гишүүд болон Цол горилогчид нь өөрийн болон бусдын хараат бус байдал, үнэн зөв дүгнэлт гаргах чадварт сөрөгөөр нөлөөлж болзошгүй ямар нэгэн бэлэг, шагнал, төлбөр болон эдгээртэй адилтгах зүйлсийг бусдад санал болгох, гуйх, бусдаас авах ёсгүй.

- C. Зөв бус төлөөлөл.** Гишүүд болон Цол горилогчид нь хөрөнгө оруулалтын судалгаа, зөвлөгөө, үйл ажиллагаа болон мэргэжлийн бусад үйл ажиллагаатай холбоотойгоор өөрөө мэдсээр байж зөв бус төлөөллийг үүсгэж болохгүй.
- D. Зүй бус үйлдэл.** Гишүүд болон Цол горилогчид нь тэдний мэргэжлийн нэр хүнд, шударга байдал болон өрсөлдөх чадварт сөрөгөөр нөлөөлөх шударга бус үйлдэл, луйвар, хулгай зэрэг үйл ажиллагаанд оролцохгүй байх ёстой.

II. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ШУДАРГА БАЙДАЛ

- A. Материаллаг, олон нийтэд нээлттэй бус мэдээлэл.** Гишүүд болон Цол горилогчид нь аливаа хөрөнгө оруулалтын үнэ цэнэд нөлөөлж болох материаллаг, олон нийтэд нээлттэй бус мэдээллийг ашиглах, эсвэл бусдад энэхүү мэдээллийг ашиглах боломж олгож болохгүй.
- B. Зах зээлийг төөрөгдүүлэх.** Гишүүд болон Цол горилогчид нь хөрөнгийн зах зээлд оролцогчдыг төөрөгдүүлэх зорилгоор үнэт цаасны үнийг гажуудуулах, эсвэл арилжааны хэмжээг зохиомлоор өсгөх үйл ажиллагаанд оролцож болохгүй.

III. ХАРИЛЦАГЧДЫН ӨМНӨ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

A. Шударга, хянуур, анхааралтай байх. Гишүүд болон Цол горилогчид нь харилцагчидтайгаа шударга харилцах үүрэгтэй ба харилцагчидтай холбоотой үйл ажиллагаандаа зохих түвшиний анхаарал хандуулж, хянуур ажиллах ёстой. Гишүүд болон Цол горилогчид нь харилцагчдынхаа ашиг сонирхлын төлөө ажиллах ёстой ба тэдний эрх ашгийг ажил олгогчынхоо болон өөрийн хувийн эрх ашгийн өмнө тавих ёстой.

B. Шударга харилцах. Гишүүд болон Цол горилогчид нь харилцагчиддаа хөрөнгө оруулалтын судалгаа илгээх, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах болон мэргэжлийн бусад үйл ажиллагаа явуулахдаа бүх харилцагчидтайгаа эрх тэгш, шударга бөгөөд хараат бусаар харилцах ёстой.

C. Нийцтэй байдал.

1. Гишүүд болон Цол горилогчид нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг харилцагчиддаа үзүүлж буй тохиолдолд дараах стандартуудыг баримтална:
 - a. Ямар нэгэн хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх эсвэл хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахаасаа өмнө харилцагчийнхаа эсвэл ирээдүйн боломжит харилцагчийнхаа хөрөнгө оруулалтын туршлага, эрсдэл ба өгөөжийн зорилт, санхүүгийн хязгаарлалтын талаар зохих түвшиний асуулга авах ба энэхүү мэдээллээ тогтсон хугацаанд шинэчилж, мэдээллийг дахин үнэлж дүгнэж байх ёстой.
 - b. Хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх эсвэл хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулахаасаа өмнө тухайн хөрөнгө оруулалт нь харилцагчийн санхүүгийн нөхцөл байдал, харилцагчийн тодорхойлсон зорилтууд, харилцагчаас олгосон зөвшөөрөл, хязгаарлалтуудтай нийцэж байгааг шалгах.
 - c. Тухайн хөрөнгө оруулалт нь харилцагчийн нийт хөрөнгө оруулалтын багцын хувьд хэр нийцтэй байгааг үнэлэх.
2. Гишүүд болон Цол горилогчид нь тодорхой заасан зөвшөөрөл, стратеги, эсвэл хэлбэрийн дагуу хөрөнгө оруулалтын багц удирдах үүрэг хүлээсэн бол зөвхөн тухайн багцын тодорхойлсон зорилт болон хязгаарлалтуудад нийцсэн хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах ёстой.

D. Гүйцэтгэлийн илтгэл.

Гишүүд болон Цол горилогчид нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг өгөхдөө энэхүү мэдээллийг тодорхой, үнэн зөв, бүрэн гүйцэт байлгахын тулд зохих түвшиний хүчин чармайлт гаргах ёстой.

E. Нууц хадгалах. Гишүүд болон Цол горилогчид нь дараахаас бусад тохиолдолд өмнөх, одоогийн болон ирээдүйн боломжит харилцагчдын талаарх мэдээллийг нууц байлгах ёстой:

1. Тухайн мэдээлэл нь одоогийн эсвэл ирээдүйн боломжит харилцагчийн хууль бус үйл ажиллагаатай холбоотой бол,
2. Хуулиар мэдээллийг задруулахыг шаардсан бол,
3. Одоогийн эсвэл ирээдүйн боломжит харилцагч нь өөрөө тухайн мэдээллийг задруулахыг зөвшөөрсөн бол.

IV. АЖИЛ ОЛГОГЧИЙН ӨМНӨ ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

A. Үнэнч байх. Гишүүд болон Цол горилогчид нь өөрийн ажил олгогчийн ашиг сонирхлын төлөө ажиллах ёстой ба ажил олгогчийн ур чадварын давуу байдлыг алдуулахгүй байх, нууц мэдээллийг задруулах болон бусад хэлбэрээр ажил олгогчдоо хохирол учруулахгүй байх ёстой.

B. Нэмэлт орлогын хэлцэлүүд. Гишүүд болон Цол горилогчид нь холбоотой бүх талаас бичгээр зөвшөөрөл авсанаас бусад тохиолдолд ажил олгогчийн ашиг сонирхолтой зөрчилдөх эсвэл сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй ямар нэгэн бэлэг, шагнал, төлбөр болон эдгээртэй адилтгах зүйлсийг авч болохгүй.

C. Хянагчийн үүрэг хариуцлага. Гишүүд болон Цол горилогчид нь өөрийн хяналт болон удирдлага дор ажиллагсад нь хууль, дүрэм, журам болон энэхүү Ёс суртахууны дүрэм болон Мэргэжлийн үйл ажиллагааны стандартыг дагаж мөрдөх талаар зохих түвшиний хүчин чармайлт гаргах ёстой.

V. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН СУДАЛГАА, ЗӨВЛӨГӨӨ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

A. Анхааралтай болон үндэслэлтэй байх. Гишүүд болон Цол горилогчид нь:

1. Хөрөнгө оруулалтын судалгаа хийх, зөвлөгөө өгөх болон үйл ажиллагаа явуулахдаа анхааралтай, хараат бус, нягт нямбай байдлыг хадгалах ёстой.
2. Хөрөнгө оруулалтын судалгаа хийх, зөвлөгөө өгөх болон үйл ажиллагаа явуулахдаа зохих түвшиний судалгаа шинжилгээн дээр суурилсан бодитой бөгөөд хангалттай үндэслэлтэй байх ёстой.

B. Одоогийн болон ирээдүйн боломжит харилцагчидтай харилцах.

Гишүүд болон Цол горилогчид нь:

1. Хөрөнгө оруулалтын судалгаа хийх, үнэт цаас сонгох болон багц бүрдүүлэхдээ ашигладаг хөрөнгө оруулалтын аргачлалынхаа үндсэн загвар болон ерөнхий зарчмуудыг одоогийн болон ирээдүйн боломжит харилцагчиддаа тайлбарлах, мөн эдгээрт ямар нэгэн нөлөөлөхүйц өөрчлөлт орсон тохиолдолд цаг тухайд нь мэдэгдэх ёстой.
2. Хөрөнгө оруулалтын аргынхаа мэдэгдэхүйц хязгаарлалтууд болон эрсдэлүүдийг одоогийн болон ирээдүйн боломжит харилцагчиддаа танилцуулах ёстой.
3. Хөрөнгө оруулалтын судалгаа хийх, зөвлөгөө өгөх болон үйл ажиллагаа явуулахад ач холбогдол бүхий хүчин зүйлсийг тогтоохдоо нарийн үндэслэлтэй хандах, эдгээр хүчин зүйлсийг одоогийн болон ирээдүйн боломжит харилцагчиддаа танилцуулах ёстой.
4. Хөрөнгө оруулалтын судалгаа болон зөвлөгөө өгөхдөө бодит баримт болон санал бодол хоёрын ялгааг сайтар гаргах ёстой.

C. Баримт хадгалах. Гишүүд болон Цол горилогчид нь өөрсдийн хийсэн хөрөнгө оруулалтын судалгаа, өгсөн зөвлөгөө, явуулсан үйл ажиллагаа болон одоогийн болон ирээдүйн боломжит харилцагчидтай харилцсан хөрөнгө оруулалттай холбоотой бусад асуудлуудыг баталгаажуулахын тулд зохих баримтуудыг бэлтгэж, хадгалах ёстой.

VI. АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

A. Ашиг сонирхлын зөрчлийн тодруулга. Гишүүд болон Цол горилогчид нь өөрийн хараат бус байдал, үнэн зөв дүгнэлтэд хүрэх чадварыг алдагдуулж болзошгүй, эсвэл одоогийн болон ирээдүйн боломжит харилцагч, ажил олгогчийнхоо өмнө хүлээсэн үүрэгтэй нь зөрчилдөж болзошгүй бүхий л асуудлын талаар үнэн зөв, бүрэн гүйцэтээр тодруулга хийх шаардлагатай. Эдгээр тодруулгууд нь ил тод, ойлгоход хялбар, мэдээллийг үр дүнтэйгээр дамжуулдаг байх шаардлагатай.

B. Арилжааны давуу эрх. Харилцагчид болон ажил олгогчийн хөрөнгө оруулалтын арилжаа нь Гишүүд болон Цол горилогчидын хувийн ашиг сонирхол бүхий арилжаанаас давуу эрхтэй байна.

C. Танилцуулсны төлбөр. Гишүүд болон Цол горилогчид нь ямар нэгэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгосны төлөө шагнал урамшуулал, ашигт зүйл болон эдгээртэй адилтгах зүйлс авсан, эсвэл бусдад төлсөн бол энэ талаар өөрийн ажил олгогч, одоогийн болон ирээдүйн боломжит харилцагчиддаа тодруулга хийх шаардлагатай.

VII. CFA ИНСТИТУТЫН ГИШҮҮН БОЛОН CFA ЦОЛ ГОРИЛОГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

A. CFA Институтын хөтөлбөрүүдэд оролцогчдын үйл хөдлөл. Гишүүд болон Цол горилогчид нь ямар нэгэн байдлаар CFA Институт болон CFA Цолны нэр хүнд болон шударга байдал, CFA Институтын хөтөлбөрүүдийн шударга, хүчин төгөлдөр, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх ямар нэгэн үйл явдалд оролцож болохгүй.

B. CFA Институт, CFA Цол болон CFA Хөтөлбөрийг иш татах. Гишүүд болон Цол горилогчид нь CFA Институт, CFA Институтын гишүүнчлэл, CFA Цол болон CFA хөтөлбөрт нэр дэвшсэн талаар ярихдаа CFA Институт, CFA Цол эсвэл CFA хөтөлбөрт нэр дэвшилтийн утга болон ач холбогдолыг гуйвуулах эсвэл дөвийлгөхийг хориглоно.

УГ ХУВИЛБАРЫГ УНШИГЧДАД НИЙЦТЭЙ БАЙЛГАХ ҮҮДНЭЭС ОРЧУУЛСАН БОЛНО. ЭНЭ ХУВИЛБАР БОЛОН АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ ЭХ ТЕКСТИЙН ХООРОНД ЗӨРҮҮ ГАРВАЛ, АНГЛИ ЭХ ХУВИЛБАРЫГ АЛБАН ЁСНЫ ХУВИЛБАР ГЭЖ ҮЗНЭ.